



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ШУУРХАЙ
ЗӨВЛӨГӨӨНӨӨС ӨГӨГДСӨН
ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ



2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр



2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр хуралдсан Засаг даргын шуурхай зөвлөгөөнөөс 4 үүрэг даалгавар өгөгдсөн байна. Үүнээс:

- Бүрэн хэрэгжсэн 1
- Хэрэгжиж байгаа 3



1. Техникийн болон улсын комиссын бүрэн бүрэлдэхүүн, дэд бүтцийн байгууллагуудын удирдлага, аймгийн ЗДТГ-ын удирдлагууд болон холбогдох албан хаагчдын уулзалтад ирцийг бүрэн хангаж оролцуулах.

Хугацаа: 03 дугаар сарын 26-ны дотор

Биелэлт: ХБТХОХ

Техникийн болон улсын комиссын бүрэн бүрэлдэхүүн, дэд бүтцийн байгууллагуудын удирдлага, аймгийн ЗДТГ-ын удирдлагуудтай хийх уулзалтыг 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулсан. Уг уулзалтаар цаг үеийн шинжтэй асуудал болон иргэдээс ирүүлж байгаа гомдлын дагуу зөрчил үүсэж байгаа нөхцөл байдал, ажиллах дүрэм журам, бодит байдал дээр ямар асуудал үүсч байгаа талаар болон цаашид хэрхэн ажиллах тухай хэлэлцсэн.

Бүрэн хэрэгжсэн – 100%





2. 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхлэх Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд иргэд, төрийн байгууллагуудад мэдээлэл хүргэх, бэлтгэл ажлыг хангах чиглэлээр Ажлын хэсэг байгуулж, хийх ажлын талаар танилцуулах.

Хугацаа: Ойрын хугацаанд



Биелэлт: ХЭЗХ

Ажлын хэсэг байгуулах захирамжийн төслийг боловсруулж и-оффис системд оруулан санал авч байна. Захирамж гарсны дараа Ажлын хэсгийг хуралдуулж, хийх ажлын төлөвлөгөө боловсруулж танилцуулахаар ажиллаж байна.

Хэрэгжилт – 10%



3. Эдийн засгийн форум зохион байгуулах Ажлын хэсгүүд цаашид хийх төсөл хөтөлбөрүүдийн төлөвлөгөөг гаргаж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулах.

Хугацаа: 04 дүгээр сарын 10-ны дотор



Эдийн засгийн форум зохион байгуулах Ажлын хэсэг 3 удаа хуралдаж, бэлтгэл ажлын төлөвлөгөө болон хөтөлбөрийг боловсруулан гаргасан. Форумын үеэр Цэвэр агаартай хот, Ухаалаг хот, Хүн ам нийгмийн бүлгүүд, Бонд гэсэн төслүүдийг танилцуулахаар бэлтгэл хангаж байна.

Хэрэгжсэн – 30%



4. Барилгын ажлыг эхлэхээс өмнө холбогдох хууль журмын дагуу баримт бичгүүдийг бүрдүүлсний дараа зөвшөөрлийг олгож байх, хүнд суртал, харилцаа хандлагын зөрчил гаргахгүй ажиллахад анхаарах.

Хугацаа: Тухай бүрд



Биелэлт: ХБТХОХ

Барилгын ажлыг эхлэхээс өмнө холбогдох хууль журмын танилцуулах хэлэлцүүлгийг 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр зохион байгуулахаар төлөвлөн удирдамж боловсруулж байна.

Хэрэгжилт – 30%



Биелэлт: ГХБХБГ

Урханы Хөдөө Ажил

Барилгын ажил эхлүүлэх үргэлжлүүлэх зөвшөөрлийн хүсэлтийг Urban.gov.mn хот байгуулалтын цахим системээр болон цаасан материалыг хүлээн авдаг.

Баримт бичгийн бүрдүүлэлт шаардлага хангагдсан тохиолдолд Барилгын тухай хуульд заасанчлан ажлын 10 хоногт багтаан шийдвэрлэн олгодог бөгөөд боломжгүй тохиолдолд иргэн хуулийн этгээдэд албан бичгээр хариу хүргүүлэн ажилладаг болно.

Хүнд суртал, харилцаа хандлагын зөрчил гаргахгүй ажиллахад анхаарч ажиллаж байна.



МОНГОЛЫН ХАМГААГАХ, ӨСӨЛДӨРЖИЛТ
ЭРХЭМЖИЛЭЛТ, ХАМГААГАХ
МОНГОЛЫН ХАМГААГАХ, ӨСӨЛДӨРЖИЛТ
ЭРХЭМЖИЛЭЛТ, ХАМГААГАХ

ӨМНӨХ 7 ХОНОГИЙН ҮҮРЭГ ДААЛГАВРААС



1.2026 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлуудын жагсаалтыг нэгтгэн бэлэн болгож, холбогдох программд 2025 оны 04 дүгээр сарын 01-ний дотор шивж оруулах. (Явцын талаар 7 хоног бүрийн шуурхай зөвлөгөөн дээр танилцуулах ажлыг зохион байгуулах)


Хугацаа: 04 дүгээр сарын 01-ний дотор



Биелэлт: ХБТХОХ

ᠮᠣᠩᠭᠡᠯᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠯ ᠠᠵᠢᠯᠢᠯᠠᠭᠠᠨᠢ ᠲᠠᠯᠠᠭᠠᠷᠬᠡ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠢᠢᠭᠢᠭ ᠣᠯᠣᠨ ᠨᠢᠶᠢᠲᠢᠶᠢᠨ ᠰᠤᠯᠵᠡᠭᠡᠢ ᠪᠣᠯᠣᠨ ᠪᠠᠭᠤᠭᠣᠳᠤᠨ ᠠᠵᠢᠯᠢᠨ ᠠᠯᠪᠠᠭᠠᠷ ᠳᠠᠮᠵᠤᠭᠤᠯᠵᠢ ᠰᠤᠷᠲᠠᠯᠴᠢᠯᠵᠢ ᠪᠠᠶᠢᠨᠠᠭᠤᠯᠤᠰ ᠲᠥᠰᠥᠪᠲᠤ 102 ᠲᠥᠷᠯᠢᠶᠢᠨ, ᠳᠠᠪᠬᠠᠷᠳᠠᠰᠠᠨ ᠪᠠᠶᠢᠳᠠᠯᠠᠷ 940, ᠤᠨᠡᠯᠭᠡᠭᠡ ᠦᠭᠰᠦᠨ 1672 ᠰᠠᠨᠠᠯ ᠪᠠᠶᠢᠨᠠᠭᠤᠯᠤᠰ.

2026 оны Улсын төсвөөр хэрэгжих төслийн санал авах үйл ажиллагааны талаарх мэдээллийг олон нийтийн сүлжээ болон багуудын ажлын албаар дамжуулж сурталчилж байна. 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар улсын төсөвт 102 төрлийн, давхардсан байдлаар 940, үнэлгээ өгсөн 1672 санал байна.



	Орхон
Төслийн санал	102
Давхардсан санал	940
Үнэлгээ өгсөн тоо	1672
Батлагдсан төсөл	0

Санал авах үйл ажиллагаа 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр дуусаж, сумдын хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтнүүдэд 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системд төслийн саналыг шивж оруулах эрх нээгдэнэ.

Хэрэгжилт – 30%



ᠠᠨᠬᠠᠶᠢᠨ ᠬᠠᠨᠳᠤᠭᠤᠯᠤᠰᠠᠨᠳᠤ ᠪᠠᠶᠢᠷᠯᠠᠯᠠᠭᠠ

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА